



ЧИНГИС ХААН
ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН ХХК

2025 ОНЫ ТАЙЛАН



АГУУЛГА

БҮЛЭГ 1. КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	3
1.1 Компанийн товч танилцуулга	4
1.2 Компанийн бүтэц, зохион байгуулалт	5
БҮЛЭГ 2. БИЗНЕСИЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ, ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА.....	8
БҮЛЭГ 3. Компанийн үйл ажиллагааны тайлан.....	11
3.1. Бизнесийн стратеги, 2025 оны зорилго, зорилтын тухай	11
3.2. Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлого, “Эрдэнэс Монгол” Нэгдлийн стратеги, бодлоготой нийцэл	13
3.3. Стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд	14
3.4. Үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	30

ЗУРАГЛАЛЫН ЖАГСААЛТ

Зураглал 1. Компанийн ерөнхий бүтэц	6
Зураглал 2. Компанийн стратегийн замнал	11
Зураглал 3. Компанийн стратеги, зорилго, зорилтын уялдаа холбоо.....	13

БҮЛЭГ 1. КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 Компанийн товч танилцуулга

Үндэсний баялгийн сангийн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 2024 оны 30 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Засгийн газрын 2025 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 42 дугаар тогтоолоор “Чингис хаан Үндэсний баялгийн сан” төрөлжсөн сангийн хөрөнгийн удирдлагын менежмент хийх бэлтгэлийг хангах, сангийн үйл ажиллагааг гадаад дотоодод сурталчлан таниулах чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 100 хувийн хувьцаа эзэмшил бүхий охин компани хэлбэрээр байгуулахаар шийдвэрлэсэн.

Үүний дагуу “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 16 дугаар тогтоолоор байгуулж, Компанийн гүйцэтгэх удирдлагыг 2025 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар тушаалаар томилсон байна.

“Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК нь Компанийн дүрэмд заасны дагуу дараах долоон чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:

1. “Чингис хаан Үндэсний баялгийн сан” төрөлжсөн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, бэлтгэлийг хангах, судалгаа хийх;
2. Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн бодлогын хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх;
3. Хуульд заасан стратегийн ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох хэлэлцээ хийхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;
4. Сангийн үйл ажиллагааг гадаад, дотоодод сурталчлан таниулах;
5. Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах;
6. Иргэдийн хуримтлалын дансны мэдээллийг төрийн үйлчилгээний цахим системээр дамжуулан ил тод тайлагнах;
7. Иргэд, олон нийтэд Үндэсний баялгийн сангийн талаарх үнэн зөв мэдээлэл өгөх, түгээн дэлгэрүүлэх, сургалт судалгаа, мэдээлэл хийх.

Алсын хараа

“Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК нь Монгол Улсын Үндэсний баялгийн сангийн үр өгөөжийг арвижуулж, иргэддээ тэгш, шударга хүртээх, тогтвортой өсөлттэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгө удирдлагын менежментийн компани болно.

Эрхэм зорилго

“Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийн эрхэм зорилго нь Монгол Улсын газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг арвижуулж, өнөө болон ирээдүйн иргэддээ тэгш, шударга хүртээх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Үнэт зүйл

Дээрх эрхэм зорилгод хүрэхийн тулд, компанийн хамт олон дараах үнэт зүйлийг эрхэмлэнэ. Үүнд:

- **Ёс зүй ба итгэлцэл**
Өндөр ёс зүйтэй, авлигаас ангид, шударга бөгөөд ил тод байдлыг эрхэмлэнэ.
- **Мэргэжлийн өндөр чадамж**
Олон улсын жишигт нийцсэн менежмент, хөрөнгө удирдлагын бодлого хэрэгжүүлж, үр дүнд суурилсан байгууллагын чадавхийг бүрдүүлнэ.
- **Ирээдүй хойч үеийн өмнөх хариуцлага**
Газрын хэвлийн баялгийг өнөө болон ирээдүйн үед тэгш шударгаар өвлүүлэх зарчмыг баримтлана.
- **Инновац, дасан зохицол**
Өгөгдөл болон технологийн дэвшилд суурилан шийдвэр гаргаж, зах зээлийн чиг хандлага, хувьсан өөрчлөлтөд түргэн шуурхай дасан зохицох соёлыг төлөвшүүлнэ.
- **Хамтын ажиллагаа, хүртээмж**

Дотоодын болон гадаадын бизнесийн түншлэлд нээлттэй байж, нийгмийн хүртээмж, хамтын үнэ цэнийг эрхэмлэнэ.

1.2 Компанийн бүтэц, зохион байгуулалт

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 16 дугаар тогтоолоор “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийн бүтэц орон тоог 2 газар, 2 алба, 1 нэгжтэй, орон тооны дээд хязгаарыг 27 байхаар баталсан. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 248 дугаар тогтоол, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 139 дугаар тогтоолоор тус компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт өөрчлөлт оруулж, Стратегийн ордын хэлэлцээр зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий 6 хүний орон тоотой нэгжийг татан буулгаж, байгууллагыг 21 хүний орон тоотой байхаар бүтцийг шинэчлэн баталсан.



Захиргаа, удирдлагын газар - Холбогдох хууль тогтоомж дүрэм журмын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаанд мэргэжил арга зүй, нэгдсэн зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, захиргаа, санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нэгжүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үндсэн чиг үүрэгтэй.

Төрөлжсөн сангуудын бодлого, зохицуулалтын газар - Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, Монголбанк зэрэг төрийн байгууллагууд, Олон Улсын Валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг хөгжлийн түнш олон улсын байгууллагууд болон бусад оролцогч талуудын үйл ажиллагааны уялдааг хангах, баялгийн сангаас зарцуулах орон сууц, эрүүл мэнд, боловсролын чиглэлээр дэмжих бодлогын асуудлаар судалгаа шинжилгээ хийх, дүрэм, журам боловсруулах, санал боловсруулах ажлыг хариуцна.

Санхүүгийн удирдлага, бодлогын алба - Сангийн хөрөнгийн менежментийн хэрэгжилтийн бэлтгэлийг хангах, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх эдийн засаг, үр ашгийн тооцоо судалгаа, бодлогыг боловсруулах, иргэний нэрийн дансны мөнгөн хөрөнгийг цахимаар ил тод тайлагнах, иргэдийн хөрөнгөө удирдах боломжийг бүрдүүлэх ажлыг хариуцна.

Олон нийттэй харилцах алба – Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагааг гадаад, дотоодод сурталчлан таниулах, олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх үндсэн зорилгын хүрээнд сэтгэгдэл, хандлагыг судалж, оновчтой агуулга бүхий сургалт, олон нийтийг хамарсан үйл ажиллагааг зохион байгуулах болон баялгийн сангуудын үйл ажиллагааны сайн туршлагыг судалж, хоёр болон олон талт хамтын ажиллагааг эхлүүлэх, түншлэлийн түвшинд хүргэх зохион байгуулалтын ажлыг хариуцна.

Стратегийн ордын хэлэлцээр зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх нэгж - Засгийн газрын Бүрэн эрхт төлөөлөгчийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд Үндэсний баялгийн сангийн хуульд заасан стратегийн ордуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох хэлэлцээртэй холбоотой болон иргэдийн санал гомдлыг шийдвэрлэх ажлыг хариуцна. (Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 248 дугаар тогтоол, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 139 дугаар тогтоолоор тус компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт өөрчлөлт оруулж, Стратегийн ордын хэлэлцээр зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий 6 хүний орон тоотой нэгжийг татан буулгаж, байгууллагыг 21 хүний орон тоотой байхаар бүтцийг шинэчлэн баталсан)

БҮЛЭГ 2. БИЗНЕСИЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ, ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

Үндэсний баялгийн сан нь улс орны газрын хэвлийн баялгийн орлогоос хуримтлал үүсгэж, ирээдүйд тогтвортой өсөлтийг бий болгох, байгалийн баялгийг одоо ба ирээдүйн иргэдэд тэгш, шударгаар хуваарилж, хуримтлуулах зорилготой. Макро эдийн засгийн орчны гол хүчин зүйлүүд болох эдийн засгийн өсөлт, инфляц, валютын ханш, түүхий эдийн үнэ, төсвийн бодлого, гадаад худалдаа зэрэг асуудлууд нь Үндэсний баялгийн сангийн орлого, хөрөнгө оруулалтын өгөөжийн тогтвортой байдалд шууд болон шууд бус байдлаар нөлөөлнө.

Эдийн засгийн хэлбэлзэл, түүхий эдийн үнийн савлагаанаас хамаарал багатай сан бүрдүүлэх нь олборлох салбараас хэт хамааралтай улс орны хувьд санхүүгийн тогтвортой байдлыг баталгаажуулна. Иймд сангийн хөрөнгийг олон улсын хөрөнгө оруулалтын санхүүгийн хэрэгслүүдэд байршуулах замаар үнэ цэнийг өсгөж, урт хугацааны өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай. Мөн санхүүгийн хямралын эсрэг хамгаалалт болгон ашиглах, гадаад, дотоод эдийн засгийн шок үүсэх үед төсвийн алдагдлыг нөхөх бус, харин урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах эх үүсвэрийг бий болгох шаардлагатай. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд одоо болон ирээдүй хойч үеийн боловсрол, эрүүл мэнд, орон сууц, технологи инновацыг нутагшуулах санхүүжилтийг дэмжиж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээж буй учраас дотоод холбогдох зах зээлийн төлөв байдлыг харгалзан үзэж судлах шаардлагатай.

Макро эдийн засгийн ерөнхий төлөв. Бүс нутгийн геополитикийн эмзэг байдал, олон улсын харилцаанд үүсч буй шинэ чиг хандлага, өр зээлийн зохистой харьцаа алдагдсан, хөрөнгө оруулалт саарсан зэрэг сорилтуудыг харгалзан үзэж, дэлхийн эдийн засгийн өсөлт 2025 онд 3.1% орчим, АНУ-ын эдийн засгийн өсөлт 2.1% болж өсөх, БНХАУ-ын өсөлт 4.2% болж саарах, Европын Холбооны эдийн засгийн өсөлт 1.1% болохоор төсөөлж байна¹. Дэлхий даяар инфляц цаашид үргэлжлэн буурах төлөвтэй байгаа ч, зарим улсад зорилтот түвшнээс дээгүүр хэвээр байх төлөвтэй байна. Тодорхой бус байдал удаан үргэлжилж, хамгаалалтын шинжтэй бодлого ихсэх нь эдийн засгийн өсөлтийг сааруулах магадлалтай байна.

Монголбанк мөнгөний хатуу бодлогыг үргэлжлүүлэн баримталж, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хамгаалах болон өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг хязгаарлах чиглэлд арга хэмжээг хэрэгжүүлсээр байна. 2025 оны 3 сард бодлогын хүүг 12% болгон нэмснээс хойш өнөөдрийг хүртэл энэхүү түвшинд хадгалан хэрэгжүүлж байгаа юм.

2025 оны гуравдугаар улиралд улсын инфляц 9.0%, Улаанбаатар хотын инфляц 9.9% байсан бол, 2025 оны арванхоёрдугаар сарын байдлаар улсын

¹ ОУБС <https://www.imf.org/en/publications/weo/issues/2025/10/14/world-economic-outlook-october-2025>

инфляц 7.5% хүртэл буурч, харин Улаанбаатар хотын инфляц 7.6% хүртэл буурсан байна.

Гадаад валютын улсын нөөц (ГВУН) нь 2025 оны 1 дүгээр сарын байдлаар 4,884.28 сая ам.долларт хүрсэн байсан бол 2025 оны 12 дугаар сарын байдлаар улсын нөөц 7,005.27 сая ам.долларт хүрч, оны эхээс 43.42% өссөн байна. Энэхүү өсөлт нь өрийн оновчтой зохицуулалт, тухайлбал Монгол Улсын Хөгжлийн банк (МУХБ)-ны бондууд, Монголбанкны своп хэлэлцээр, Засгийн газраас Хуралдай бонд, Гэрэгэ бонд зэргийг төрийн сангийн мөнгөн хөрөнгө болон дахин санхүүжилт хийснээр эргэн төлж, гадаад валютын нөөц нэмэгдсэнтэй холбоотой юм.

Гол түүхий эдийн зах зээлийн төлөв байдал. 2025 оны дөрөвдүгээр улирлын байдлаар Монгол Улсын экспорт 15.7 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.52 хувиар буурсан байна². Цаашид экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ өндөр түвшинд тогтвортой хадгалагдах төлөвтэй байгаа хэдий ч зэсийн болон цайрын баяжмалаас бусад голлох бүтээгдэхүүний хилийн үнэ гадаад орчны нөлөөгөөр буурахаар хүлээгдэж байна³. Нүүрсний экспортын биет хэмжээ 2025 онд 90.0 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар өслөө. 2025 оны 12 дугаар сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 9.0 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 602 сая ам.долларын орлого олжээ. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2025 оны эхний 12 сард 21.8 сая тонн нүүрс, 5.9 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 51.5 мянган тонн жоншны баяжмал, 45.3 мянган тонн зэсийн баяжмал арилжаалаад байна.

Хууль эрх зүйн орчны шинжилгээ. “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийн үйл ажиллагаа нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 4.1.2-т заасан төрөлжсөн сангуудын хөрөнгө удирдлагын бэлтгэлийг хангах болон Үндэсний баялгийн сангийн талаар олон нийтэд зөв, ил тод мэдээлэл түгээх үндсэн чиглэлтэй. 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын 34 дэх Ерөнхий сайдаар Г.Занданшатар томилогдож, Засгийн газрын бүтцээ танилцуулахдаа Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулан Үндэсний баялгийн сангийн асуудлыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын хамаарах асуудалд оруулсан.

Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатарын тэргүүлж буй Засгийн газраас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар 2025 оны 02 дугаар сард байгуулагдсан Ажлын хэсгийн ажлын тайланг дүгнэсний үндсэн дээр Үндэсний баялгийн сангийн хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх Ажлын хэсгийг ЗГХЭГ-ын дарга С.Бямбацогтоор ахлуулан 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдөр 72 дугаар захирамжаар байгуулсан бөгөөд тус ажлын хэсэг нь улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн стратегийн орд газруудын өгөөжийг

² Сарын статистик бюллетень, Монголбанк, 2025 оны 9-р сар, Монголбанк Статистик <https://stat.mongolbank.mn>

³ Монгол улсын гадаад худалдааны тэнцэл, гол нэр төрлийн экспорт, импортын тоо хэмжээ, үнэ болон татварын орлого бүрдүүлэлтийн талаарх товч танилцуулга, Улсын Их Хурлын Тамгын газрын хяналт шалгалтын газрын төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс, 2025 он, №ГХ06

Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх хэлэлцээрийг эрчимжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах, холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах үүрэг даалгавар өгсөн. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/144 тушаалаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл орд дээр үйл ажиллагаа явуулж байгаа болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх талаар хэлэлцээ хийх бэлтгэл ажлыг хангах, хэлэлцээ хийхэд шаардлагатай бүх талын дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан болон хууль, эрх зүйн асуудал хариуцсан ажлын хэсгүүдийг байгуулан ажиллуулж буй бөгөөд тус ажлын хэсгүүдэд “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийн шинжээч нар орж ажиллаж байна.

Түүнээс гадна, Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг танилцуулж, Монгол Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн, 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр соёрхон батлагдсан. Тус бодлогын баримт бичгийн 4.1.5-д зааснаар Үндэсний баялгийн сангийн асуудлыг Эдийн засаг, хөгжлийн яам хариуцах бөгөөд Үндэсний баялгийн сангийн хараат бус, бие даасан, ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн ашиглалтын хяналтын механизм бий болгох замаар Үндэсний баялгийн сангийн иргэдэд хүрэх өгөөжийг нэмэгдүүлэх үр дүнд чиглэж ажиллахаар тодорхойлж, Үндэсний баялгийн сангийн талаарх Засгийн газрын бодлого тогтвортой үргэлжилнэ гэдгийг тодотгосон.

БҮЛЭГ 3. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

3.1. Бизнесийн стратеги, 2025 оны зорилго, зорилтын тухай

“Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК нь 2025 оны бизнес төлөвлөгөөг Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа 2050,” Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, “Эрдэнэс Монгол” Нэгдлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө, олон улсын засаглалын зохистой зарчмууд, Компанийн Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйл, Зарчим-д үндэслэн боловсруулсан.

Компанийн урт, дунд хугацааны стратеги

Компани нь “Монгол Улсын Үндэсний баялгийн сангийн үр өгөөжийг арвижуулж, иргэддээ тэгш, шударга хүртээх, тогтвортой өсөлттэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгө удирдлагын менежментийн компани болох” алсын хараатай, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг арвижуулж, өнөө болон ирээдүйн иргэддээ тэгш, шударга хүртээх нөхцөлийг бүрдүүлэх эрхэм зорилгод хүрэхийг эрмэлзэн стратегийг дараах байдлаар тодорхойлов. (Зураглал 2).

Зураглал 2. Компанийн стратегийн замнал



Төрөлжсөн сангуудын хөрөнгө удирдлагын бэлтгэл хангах үе шат (2025 он)

Төрөөс хэрэгжүүлж буй төрөлжсөн сангуудын бодлого, хэрэгжилтийн уялдаа холбоог сайжруулахад судалгаа шинжилгээнд суурилсан мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, сангийн хөрөнгийн хуримтлалыг арвижуулах бэлтгэл ажлыг зохион байгуулж, олон нийтийн оролцоог ханган, гадаад, дотоод хамтын ажиллагааг эхлүүлэх буюу сангийн үйл ажиллагааны **суурь нөхцөл бүрдүүлэх үе шат**.

Хөрөнгө удирдлагын нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх үе шат (2030 он)

2030 он гэхэд төрөлжсөн сангуудын хөрөнгийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, сангийн хуримтлалыг олон нийтэд хүртээмжтэй, шударга, үр ашигтай зарцуулах механизм, санхүүгийн зохистой загваруудыг нэвтрүүлж, засаглалын зохистой зарчмуудыг бэхжүүлэх сангийн **төлөвшүүлэх үе шат**.

Үндэсний баялгийн сангийн засаглалыг төгөлдөржүүлэх үе шат (2050 он)

2050 он гэхэд тогтвортой өсөлттэй, ил тод, нээлттэй, хараат бус, байгалийн баялгийн өгөөжийг иргэдэд хүртээмжтэй хуваарилах тогтолцоо, сайн засаглал бүхий олон улсад өрсөлдөх чадвартай Үндэсний баялгийн сан болж **бүрэн төлөвших үе шат**.

Компанийн зүгээс баялгийн сангийн нэгдсэн хөрөнгө удирдлагын суурь нөхцөл бүрдүүлэх үе шат буюу 2025 онд хэрэгжүүлэх стратегийн хүрээнд төрөлжсөн сангуудын бодлого, хэрэгжилтийн уялдааг сайжруулах, сангийн орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх, компанийн бизнесийн загвар буюу төрөлжсөн сангуудын үйл ажиллагаанаас орлого олох санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгийн хуримтлал, арвижуулалтын бэлтгэл ажлыг системтэй, үе шаттайгаар хэрэгжүүлэх нэн тэргүүний зорилт болгон тодорхойлж байна.

Мөн олон нийт болон мэргэжлийн оролцогч талуудын ойлголт, дэмжлэгийг нэмэгдүүлэх, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг эхлүүлж, сайн туршлага, засаглалын зарчмыг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх нь энэхүү төлөвлөгөөний гол зорилгуудын нэг бөгөөд нь дараагийн хөгжлийн үе шат руу шилжих суурь нөхцөл болно гэж үзэж байна.

“Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК нь 2025 онд Компанийн дүрэмд заасан үйл ажиллагааны үндсэн чиглэлийн дагуу нийт 5 стратегийн зорилгын хүрээнд 15 зорилтыг дэвшүүлж, 44 цогц арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн. (Зураглал 3 ба Хавсралт 1)

Зураглал 3. Компанийн стратеги, зорилго, зорилтын уялдаа холбоо

Стратеги		
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО	2025 ОНЫ ЗОРИЛТ	АРГА ХЭМЖЭЭ
Төрөлжсөн сангуудын бодлогыг уялдуулж хэрэгжилтийг хангахад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх	Үндэсний баялгийн сангийн засаглалын бэхжүүлэх	7 үйл ажиллагаа
	Сангийн цахимжуулалт, цахим шилжилтийн дэд бүтцийн суурийг бэхжүүлэх	
	Бодлого, шийдвэр гаргалтад үр нөлөөтэй оролцох замаар мэргэжлийн чадавхыг бэхжүүлэх	
Сангийн хуримтлалыг арвижуулах бэлтгэл ажлыг зохион байгуулах	Олон улсын зах зээлд хөрөнгө удирдах "Замын зураглал" гаргах	10 үйл ажиллагаа
	Компанийн орлогыг тогтворжуулж, үйл ажиллагааны санхүүжилтийг тодорхой болгох	
	Стратегийн ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох хэлэлцээ хийхэд дэмжлэг үзүүлэх	
	Сангийн эрсдэлийн удирдлагын бодлого тодорхойлох	
Үндэсний баялгийн сангийн талаарх зав ойлголтыг сурталчлан таниулах	Баялгийн тэгш хүртээмж, зөв зарцуулалт болон ач холбогдлын талаар олон нийтэд мэдлэг түгээх	4 үйл ажиллагаа
Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаа эхлүүлж, засаглалын зохистой зарчмуудыг нэвтрүүлнэ	Хамтын ажиллагаа эхлүүлэх суурийг тавих	6 үйл ажиллагаа
	Хөрөнгө оруулалтын түншлэлийн суурийг бэхжүүлэх	
Байгууллагын дотоод чадавхийг бэхжүүлнэ	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, компанийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх	17 үйл ажиллагаа
	Санхүүгийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангаж, төсвийг зүй зохистой зарцуулж, тайлагнах	
	Архив албан хэрэг хөтөлөлтийг стандартын дагуу эрхлэн хөтлөх	
	Чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, ажилтны нийгмийн баталгааг хангах	
	Компанийн үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага, дотоод аудитыг хэрэгжүүлэх	

3.2. Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлого, “Эрдэнэс Монгол” Нэгдлийн стратеги, бодлоготой нийцэл

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-ийн 4.6-д “Эдийн засгийн төрөлжилт, инновац, шинэ технологи, хүний хөгжил, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгоно” гэж заасан. Баялгийн санг бий болгох зорилтын хүрээнд “Үндэсний баялгийн сангийн тухай хууль”-ийг 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр баталж, тус хуульд заасан дагуу орлого төвлөрүүлэгч төрийн өмчит хуулийн этгээд буюу Монгол Улсын эрдэс баялгийн салбарт төрөөс хэрэгжүүлэх менежментийн үйл ажиллагааг явуулж, Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 100 хувь эзэмшил бүхий охин компани хэлбэрээр “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК үүсгэн байгуулагдсан. Стратеги удирдлага, менежментийн түвшинд “Эрдэнэс Монгол” ХХК нь Нэгдлийн хэмжээнд мөрдөгдөх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн бодлого, журам, стандарт болон холбогдох бусад баримт бичгийг батлуулан мөрдүүлэхээр заасан ба энэ хүрээнд “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК нь “Эрдэнэс Монгол” Нэгдлийн охин компани болохын хувьд компанийн стратеги, бодлогыг нэгдлийн стратеги, бодлоготой нийцүүлэн тодорхойлов.

Төрөлжсөн сангуудын хөрөнгийн менежментийн бэлтгэлийг хангах зорилгын хүрээнд Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагааг бэхжүүлэх, чиг үүргийг тодорхой болгох зорилгоор Компанийн Дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.2.2-т заасан үйл ажиллагаа болох (i) “Чингис хаан Үндэсний баялгийн сан” төрөлжсөн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах, судалгаа хийх, (ii) Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн бодлогын хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх, (iii) хуульд заасан стратегийн ордын төрийн эзэмшлийн хувь

хэмжээг тогтоох хэлэлцээ хийхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, (iv) Сангийн үйл ажиллагааг гадаад, дотоодод сурталчлан таниулах, (v) Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, (vi) Иргэдийн хуримтлалын дансны мэдээллийг төрийн үйлчилгээний цахим системээр дамжуулан ил тод тайлагнах, (vii) олон нийтэд Үндэсний баялгийн сангийн талаарх үнэн зөв мэдээлэл өгөх, түгээн дэлгэрүүлэх, сургалт, судалгаа, мэдээлэл хийх үйл ажиллагааг эрхлэн явуулж байна. Үндсэн үйл ажиллагааны цар хүрээг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааны стратеги, бодлоготой нийцүүлэн 2025 оны бизнес төлөвлөгөөнд дурдсан ажлуудыг үе шаттайгаар хийж, хэрэгжүүлэн ажилласан байна.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2024-2028 оны стратеги төлөвлөгөөнд авч үзсэн голлох нэг чиглэл нь Нэгдлийн үйл ажиллагааг иргэд олон нийт, оролцогч талуудад сурталчлан таниулж, олон нийтийн дунд эерэг хандлагыг түгээх явдал. Энэхүү бодлого нь нэгдэлд хамаарах төсөл хөтөлбөрүүд болон нэгдлийн дунд хугацааны стратегийн хэрэгжилт, үйл явцыг олон нийтэд сурталчлан таниулах үйл ажиллагааг хамрах тул компанийн Дүрэмд заасан үйл ажиллагааны зорилго⁴ нь нэгдлийн 2025 оны стратегийн зорилготой нийцэж байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т “Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын бодлого” гэж санхүүгийн жилийн макро эдийн засгийн орчин, мөнгөний бодлоготой уялдуулан гаргасан хөрөнгө оруулалтын хэрэгслийн үр өгөөжийн доод хэмжээ болон эрсдэлийн дээд хэмжээний жишиг үзүүлэлтийг тогтоосон хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийг” гэж заасныг үндэслэл болгон авч үзвэл сангийн хөрөнгө удирдлагын үйл ажиллагаа нь санхүүгийн жилийн макро эдийн засгийн орчин, мөнгөний бодлоготой уялдуулан гаргасан байх учиртай бөгөөд Үндэсний баялгийн сангийн хөрөнгө удирдлагын бодлогыг Үндэсний баялгийн сангийн тухай хуульд зааснаар чиглэлийн яамдууд төслийг боловсруулж, Засгийн газар батлах бөгөөд Засгийн газар нь “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн хувиар “Эрдэнэс Монгол” ХХК-д батлагдсан хөрөнгө удирдлагын бодлоготой өөрийн стратеги, бодлогыг нийцүүлж, Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангуудын хөрөнгийн удирдлагыг мэргэжлийн, хараат бус зарчмаар хэрэгжүүлэх бэлтгэлийг хангахад бүх талаар дэмжлэг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага байна.

3.3. Стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд

2025 онд тус компани нь Чингис хаан Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангуудын хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, эрх зүйн болон институцийн суурийг бэхжүүлэх, дотоод зохион байгуулалтаа бүрдүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилтуудын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэв. Үүнд:

3.3.1. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГАД СУУРИЛСАН ТӨРӨЛЖСӨН САНГУУДЫН ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА, ЗАРЦУУЛАЛТ,

⁴ “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийн Дүрмийн 1-р зүйлийн 1.2.1-р заалт

МЕНЕЖМЕНТИЙН СТРАТЕГИЙГ ТОДОРХОЙЛЖ, БЭЛТГЭЛ ХАНГАЖ АЖИЛЛАВ.

3.3.1.1. Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сангийн нөхцөл байдлын шинжилгээг хийж, олон улсад тэргүүлэгч Норвеги, Сингапур, АНЭУ, Ирланд, Австрали, Шинэ Зеланд, Казахстаны баялгийн сан, шинээр байгуулагдсан болон байгуулагдаж буй Индонези, АНУ-ын баялгийн сангуудын хөрөнгө удирдлагын стратегийг харьцуулж, Чингис хаан Үндэсний баялгийн санд тусгах хөрөнгө удирдлага, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах шийдлүүдийг менежментийн стратегийн саналд тусгав.

3.3.1.2. Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2025 оны 4 дүгээр сарын 19-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээс хойш нэг жилийн хугацаанд Засгийн газраас иргэн бүрт Хуримтлалын нэрийн данс нээж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зорилгоор зарцуулах боломжийг бүрдүүлэх, холбогдох дүрэм журмыг батлах зэрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, явцын танилцуулга, Монгол Улсын Ерөнхий сайдын илтгэл, Улсын Их Хурлын даргын гадаад айлчлалын ярианы сэдэв, D-Parliament системээр иргэдийн ирүүлсэн асуултад хариу бэлдэх зэргээр дэмжлэг үзүүлж ажилласан.

3.3.1.3. Олон улсын баялгийн сангууд нийтлэг мөрддөг засаглалын Сантьяго зарчмууд болон манай улсын баялгийн сангийн хууль тогтоомжийн нийцлийг үнэлж, судалгааны тайлан боловсруулж, санал, зөвлөмжийг холбогдох төрийн захиргааны байгууллага, бусад шийдвэр гаргагч нарт танилцуулж, хүргүүлэв. Тухайлбал, баялгийн сангийн талаар боловсруулсан 5 цогц судалгааны хураангуйг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Гэр бүл, нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яам, Эрдэнэс Монгол ХХК-ийн шийдвэр гаргагч болон холбогдох албан тушаалтан нарт танилцуулж санал солилцож, дэлгэрэнгүй 173 хуудас тайланг албан бичгийн хамт 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэв. Түүнчлэн, Улсын Их Хурлын гишүүдэд Үндэсний баялгийн сан, компанийн үйл ажиллагаа, Үндэсний баялгийн сангийн хуулийн хэрэгжилтэд анхаарах асуудлууд, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх агуулга бүхий танилцуулга бэлтгэн хүргүүлэв.

3.3.1.4. Чингис хаан Үндэсний баялгийн сангийн удирдлагын тогтолцоог олон улсын баялгийн сангуудын сайн туршлагын дагуу бэхжүүлэх зорилгоор Сантьяго зарчим, баялгийн сангийн талаарх хууль тогтоомжийн нийцлийг үнэлэх судалгаанд суурилан Үндэсний баялгийн сангийн засаглалын зарчмыг нарийвчлан тодорхойлж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний замын зураглал гаргав.

3.3.1.5. Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангуудын хөрөнгө удирдлагыг хэрэгжүүлэх, эрх зүйн үндэс суурийг бэхжүүлэх хүрээнд Үндэсний баялгийн сангийн хууль тогтоомж, тэдгээрийн хоорондын уялдаа, холбоо, хэрэгжилтэд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, түүнд үндэслэсэн хөрөнгийн удирдлага хэрэгжүүлэх институцийн засаглалын бүтцийг сайжруулах чиглэлээр судалгааг боловсруулж, санал, зөвлөмжийн хамт холбогдох байгууллагад хүргүүлэв.

3.3.1.6. Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангуудын үйл ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлэгч төрийн захиргааны төв байгууллагууд болон тэдгээрийн шийдвэрийг хэрэгжүүлэгч Засгийн газрын агентлагуудтай давхардсан тоогоор нийт 30 орчим уулзалтыг зохион байгуулж, Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, үйл ажиллагаа, бодлого, журмын биелэлтийн талаар харилцан санал солилцож, нэн шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллав.

3.3.1.7. Үндэсний баялгийн сангийн экосистем дэх гол оролцогч талуудыг судалж сангийн засаглалын бүтцийг сайжруулах, оролцогч талуудын чиг үүргийн уялдааг сайжруулах зорилгоор Хөгжлийн банк, холбогдох яамд, агентлагийн товч судалгааг боловсруулав.

3.3.1.8. Хамтын ажиллагааг эхлүүлэх, хөрөнгө оруулалтын түншлэлийн суурийг бэхжүүлэх, мэргэжлийн туршлага солилцох болон дотоод чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор олон улсын байгууллагуудтай нийт 83 цахим болон биет уулзалтууд зохион байгуулав. Түншлэлийн хэлэлцээрийн эхний шатны арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, шаардлагатай танилцуулга материал, мэдээллийг хүлээн авч, цаашдын хамтын ажиллагааны боломжуудыг тодорхойлох чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. Үүнд:

- Мэргэжлийн туршлага солилцох, дотоод чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын баялгийн сангууд болох АНУ-ын Аляска сан (Alaska Permanent Fund Corporation), Арабын Нэгдсэн Улсын Мубадала (Mubadala Investment Company), Катар Улсын Хөрөнгө оруулалтын сан (Qatar Investment Authority), Абу Дабигийн Хөрөнгө оруулалтын сан (Abu Dhabi Investment Authority), Сингапур Улсын Хөрөнгө оруулалтын корпораци (Government of Singapore Investment Corporation), Темасек (Temasek), Бүгд Найрамдах Казахстан Улсын Сампрук-Казына сан, Норвегийн хаант Улсын NBIM (Norges Bank Investment Management) болон Дэлхийн Банкны төлөөлөгчидтэй ганцаарчилсан уулзалтуудыг зохион байгуулж, харилцаа холбоотой ажиллаж байна. Тухайлбал, Норвегийн хаант Улсын NBIM-ны баялгийн сангийн сайн засаглал, ил тод сангийн удирдлагын туршлагыг нутагшуулахаар судалж байгаа ба Дэлхийн банктай баялгийн удирдлагын мэргэжлийн хүний нөөц бэлтгэх дээр хамтран ажиллахаар хэлэлцэж байна.
- Олон улсын хөрөнгө удирдлагын сайн туршлагыг нутагшуулах зорилгоор дараах байгууллагуудтай холбоо тогтоон уулзалтууд зохион байгуулж, харилцаа холбоотой ажиллаж байна. Үүнд:
 - Олон улсын тэргүүлэгч хөрөнгө удирдлагын байгууллагууд болох БлэкРок (Blackrock), Стейт Стрит (State Street) болон Жи Пи Морган (J.P.Morgan) байгууллагуудтай хөрөнгийн зах зээлийн зөвлөх үйлчилгээ, кастодиан, ETF санхүүгийн хэрэгсэл болон хөрөнгө удирдлагын менежментын үйлчилгээнүүдийн талаар санал солилцож, хамтын ажиллагааны боломжуудыг эрэлхийлж байна.
 - PIMCO (Pacific Investment Management Company), Франклин Темплетон (Franklin Templeton Investments) байгууллагуудтай мульти

ассет хөрөнгийн удирдлага болон хөгжиж буй орнуудын Засгийн Газрын бондын багцын удирдлагын туршлагын талаар санал солилцож, харилцаа холбоотой ажиллаж байна.

- Азийн Хөгжлийн Банк, Азийн Дэд Бүтэц, Хөрөнгө Оруулалтын банк (Asian Infrastructure Investment Bank) болон Дрэгон Три Капитал (Dragon Tree Capital)-тай холбоо тогтоож, төслийн санхүүжилтийн загвар хөгжүүлэлтийн туслалцаа, санхүүжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлтүүд, өгөөжийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан Монгол Улсын дэд бүтцийн төслийн зээлийн санхүүжилт, хамтарсан хөрөнгө оруулалтын талаар хэлэлцэв.
- Филлип Капитал (Phillip Capital Group), Кастл Оук Секьюритис (Castle Oak Securities), Кэньён Партнерс (Canyon Partners)-тай хаалттай зах зээл, хөрвөх чадвар өндөртэй мөнгөний зах зээлийн хэрэгслийн талаар хэлэлцэж, судлав.

3.3.1.9. Сангийн менежментийн компанийн орлогын эх үүсвэрийг оновчтой тогтоох хүрээнд олон улсын баялгийн сангуудын менежментийн бүтэц, орлогын загварын онцлогийг судалж, хөрөнгө удирдлагын менежментийн төлбөр, хөрөнгө оруулалтын үйлчилгээний орлого, хамтарсан хөрөнгө оруулалтаас олох орлого, дижитал санхүүгийн үйлчилгээний орлого, мөн төсвийн шууд санхүүжилтийн хэлбэрээс зохимжит хувилбарыг сангийн хөрөнгө удирдлагын стратегийн төсөлд тусгав. Мэргэжлийн ХОМК-ийн менежментийн төлбөрийн хувьд тухайн менежерийн олсон хөрөнгө оруулалтын орлогоос хасагдуулж тооцон цэврээр сангийн орлогыг бүртгэх нь олон улсын туршлагад нийцэж байна. Эдгээр гаргалгааг цаашид сангийн хөрөнгө удирдлагын стратегид тусган ажиллана.

3.3.1.10. Төрөлжсөн сангийн хөрөнгө удирдлагын бодлогод тусгагдсан багц бүрдүүлэлтийг олон улсын сайн туршлагад үндэслэн санхүүгийн хэрэгсэл бүрт дан болон нийлмэл бенчмаркыг уяж, хүлээж болох эрсдэлийн түвшингээр тохируулга хийж зорилтот өгөөжийг тодорхойлов. Түүнчлэн хууль эрх зүй, засаглалын бүтцээс эхлэн кастодиан гэрээ, арилжаа, эрсдэл, санхүү, тайлан үнэлгээний үйл ажиллагаа хүртэлх хөрөнгө удирдлагыг хэрэгжүүлэх үе шатлалт бүхий замын зураглалыг боловсруулав. Мөн Ирээдүйн өв сангийн батлагдсан хөрөнгө удирдлагын бодлогын хэрэгжилтийн хүрээнд төв банкны нөөцийн удирдлагын бодлого, хөрөнгө оруулах боломжит санхүүгийн хэрэгслийн цар хүрээ, хөрөнгө оруулалтын харьцаа зэргийг шинжилж, хөрөнгө удирдлагын бодлогыг сайжруулах зөвлөмж боловсруулсан.

3.3.1.11. Хуримтлалын сангийн хөрөнгө удирдлагын бодлогын хэрэгжилтийн хүрээнд Үндэсний баялгийн сангийн тухай хууль, дагаж мөрдөх журам, заагдсан гэрээг шинжилж зөвлөмж боловсруулав. Түүнчлэн ипотекийн зээлээр баталгаажсан бондын (ИЗББ)-ын хоёрдогч зах зээлийг идэвхжүүлэх замаар орон сууцны санхүүжилтийн хүртээмжийг өргөжүүлэх, зах зээлийн эргэлтийг сайжруулах давхар зорилготой хосолмол хөрөнгө удирдлагын бодлогын санал боловсруулж, ЗГХЭГ-т танилцуулсан. Судалгааны үр дүнд төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны санхүүжилтийн тогтолцоог сайжруулах, санхүүжилтийг нэмэгдүүлж иргэдийн орон сууцтай болох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор боломжит хувилбаруудыг боловсруулж, төсөөллийг гаргасан бөгөөд

цаашид орон сууцны бодлого, эрэлт, нийлүүлэлтийн уялдааг сайжруулах чиглэлээр бодлогын санал, зөвлөмжийг тусгав.

3.3.1.12. ГБХНХЯ-наас санаачлан төрийн цахим үйлчилгээний И-Монголиа системээр 2025 оны 05 дугаар сарын 16-23-ны өдрүүдэд авсан “Хуримтлалын санд хуримтлал хийх тухай” санал асуулгад оролцсон иргэдийн нээлттэй хариултыг шүүж, боловсруулалт хийв. Санал асуулгын үр дүнгийн танилцуулгыг ГБХНХЯ-наас авч, архивласан.

3.3.1.13. Үндэсний баялгийн сангийн эх үүсвэр, зарцуулалт, нэрийн дансны талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй, цахим хэлбэрээр хүргэх хүрээнд дараах уулзалтуудыг хийв.

- Үнэт цаасны Төвлөрсөн хадгаламжийн төвийн удирдлагуудтай уулзалт хийж, “Эрдэнэс Тавантолгой” (ЭТТ) ХК-ийн хувьцааны ногдол ашгийг хуримтлуулах болон Хөгжлийн санд хандивлах санал өгсөн иргэдийн мөнгийг Монголбанкна дахь дансанд шилжүүлэх, иргэдийн И-Монголиа дахь хуримтлалын нэрийн дансны мэдээллийг цаг тухайд нь шинэчилж байх талаар мэргэжлийн дэмжлэг үзүүлж ажиллав.
- ГБХНХЯ-ны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн газрын дарга, мэргэжилтнүүдтэй Хуримтлалын сангийн бодлого, стратеги, бодлогын хэрэгжүүлэлттэй холбоотой гарч буй асуудал, шийдэл сэдвээр ГБХНХЯ-ны удирдлагуудтай зөвлөлдөх уулзалт хийж, зарим сэдвээр нарийвчлан судлахаар тохиролцсон.

3.3.1.14. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, Ашигт малтмалын тухай хуульд заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх асуудлаар санал боловсруулах, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж дараах танилцуулга, саналыг боловсруулав. Үүнд:

- ЗГХЭГ-ын ажлын алба, “Эрдэнэс Монгол” ХХК, “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК, “Эдийн засгийн хөгжлийн төв” ТББ-ын тус тусдаа боловсруулсан бодлогын судалгаа болон санхүүгийн загварчлалыг нэгтгэж, нэгдсэн танилцуулга, саналыг бэлтгэв.
- Төрөлжсөн сангуудын эх үүсвэрийн бүрдүүлэлт, эх үүсвэрийн хуваарилалт, хөрөнгө удирдлагын бодлого, зарцуулалтын бодлогын уялдааг тодорхойлж, Үндэсний баялгийн сангийн хууль тогтоомжийн хүрээнд хэрхэн сайжруулах талаар хувилбаруудыг боловсруулж, шаардлагатай үйл ажиллагааны замын зураглал гаргаж албан даалгаврыг гүйцэтгэв.
- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл орд дээр үйл ажиллагаа явуулж байгаа болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй хийх хэлэлцээрийн бэлтгэл ажлыг санхүү, эдийн засгийн чиглэлээр дэмжих дэд ажлын хэсэгт орж, нүүрсний чиглэлийн хоёр, үүсмэл зэсийн гурван компанийн тоон өгөгдлийг нэгтгэж, түүхэн гүйцэтгэлд үндэслэн санхүүгийн шинжилгээ хийв.

- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл орд дээр үйл ажиллагаа явуулж байгаа болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй хийх хэлэлцээрийн бэлтгэл ажлыг хууль, эрх зүйн чиглэлээр дэмжих дэд ажлын хэсэгт орж, зэсийн үүсмэл ордууд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч тодорхой компанийн баримт бичигт хууль зүйн магадлан шинжилгээ хийж, тайлан боловсруулав.

3.3.1.15. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын журмын олон улсын туршлагыг судлан, төслийн загварыг боловсруулав. Түүнчлэн, хөрөнгө оруулалтын үзүүлэлтийн өдрийн тайлангийн загварын бэлтгэв. Уг тайлан нь хөрөнгө оруулалтын багцад хуваарилсан санхүүгийн хэрэгслийн ангилал тус бүрээрх ханшийн өөрчлөлт, цэвэр хөрөнгийн үнэ (NAV), гүйцэтгэлийн шинжилгээнээс гадна, эрсдэлийн хэмжүүр үзүүлэлтийг хураангуй болон дэлгэрэнгүй байдлаар хянах боломжтой байдлаар бэлтгэсэн. Цаашид эрсдэлийн зааг хэмжээнээс доогуур түвшинд үзүүлэлтүүдийн нэг нь орж ирэхэд гүйцэтгэлийн багт дохиолох, мөн уг тайлангийн давтамжийг өөрчлөн удирдлагын багт тайлагнах хэрэгсэл болгож сайжруулахаар ажиллаж байна.

3.3.1.16. Ирээдүйн өв сангийн хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд олон улсын зах зээлд үйл ажиллагаа явуулж, хөрөнгө удирдлагын чиглэлээр тэргүүлэгч баялгийн сангууд болох Норвегийн хаант Улсын Засгийн газрын тэтгэврийн сан (Government Pension Fund Global), Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндэсний сан (National Fund of the Republic of Kazakhstan), Чили Улсын тэтгэврийн нөөцийн сан (Pension Reserve Fund), Ботсвана Улсын Пула сан (Pula Fund), Азербайжан Улсын газрын тосны сан (State Oil Fund of the Azerbaijan), болон Филиппин Улсын Махарлика хөрөнгө оруулалтын сан (Maharlika Investment Fund)-гуудын өгөөж, эрсдэлийн түвшин, хөрөнгө оруулалтын дундаж хугацаа зэрэг үзүүлэлтүүдийг шинжлэх замаар Ирээдүйн өв сангийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг инфляцаас багагүй түвшинд бодитоор нэмэгдүүлэх саналыг боловсруулав. Түүнчлэн Хуримтлалын сангийн хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд өнөөгийн ипотекийн санхүүжилт давамгайлсан хөрөнгө удирдлагын бүтцийг төрөлжүүлэхэд төвлөрч, дотоодын хөрөнгийн зах зээл дээрх Засгийн газрын дотоодын үнэт цаас (ЗГДҮЦ), нээлттэй хувьцаа болон мөнгөний захын хэрэгслүүдэд суурилсан хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлэх замаар өгөөжийг нэмэгдүүлэх боломжит хувилбарыг боловсруулав.

3.3.1.17. Ирээдүйн өв сангийн багцын хөрөнгө оруулалтын эрсдэлийн зааг хэмжээг тодорхойлох зорилгоор өнөөгийн батлагдсан хөрөнгө оруулалтын бодлогод үндэслэн шинжилгээ хийв. Шинжилгээний үр дүнд жишиг багцын ахиу эрсдэл авах сонирхлоос хамаарч багцын хөрвөх чадвар, эрсдэлээр жигнэсэн хүлээгдэж буй өгөөж (Sharpe харьцаагаар илэрхийлсэн), тогтмол орлоготой үнэт цаасны хугацаа, багцын цэвэр хөрөнгийн үнийн савлагаа зэргийн зааг хэмжээг тодорхойлов. Түүнчлэн, хөрөнгийн багцын хамгийн их алдагдлын магадлалаа (VaR), жишгээс хазайх хэмжээг олон улсын стандарт аргачлалаар тооцож үзсэн бөгөөд цаашид уг үр дүнд суурилан шинэчилсэн хөрөнгө удирдлагын бодлогыг боловсруулах боломжтой болж байна.

3.3.1.18. Хуримтлалын сангийн хөрөнгө удирдлагын бодлогыг оновчлох зорилгын хүрээнд дотоодын хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд (ХОМК)-ын бүтэц, үйл ажиллагаа, үйлчилгээний цар хүрээ, хөрөнгө удирдах

чадавхын талаар судалгааг олон нийтийн болон зохицуулагч байгууллагын ил мэдээллийн бааз, салбарын тайлан, Санхүүгийн зохицуулах хорооны мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийв. Үндэсний баялгийн сангийн зүгээс дотоодын хөрөнгийн захын үйл ажиллагааг дэмжих хүрээнд цаашид дотоодын ХОМК-уудтай хамтран ажиллах боломжийг үнэлэх, сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт боловсруулах, мөн хөрөнгийн удирдлагын гэрээт харилцааг илүү оновчтой төлөвлөх суурь судалгааг хийв.

Тайлант жилд гадаадын мэргэшсэн ХОМК-тай хөгжүүлсэн хамтын ажиллагаа өргөжин тэлж буйтай уялдуулан, шалгуур үзүүлэлтээр үнэлж сонгон шалгаруулах үйл ажиллагааг илүү шуурхай, үр ашигтай болгох зорилгоор шийдвэр гаргалтын матрицыг боловсруулав.

3.3.1.19. Хөгжлийн сангийн засаглал, хөрөнгө оруулалтын стратеги, хөгжлийн бодлогын уялдаа, хөрөнгө оруулалтын бодлогын суурь судалгааг хийж, гадаад санхүүжилтийн эх үүсвэр татах замаар дотоодын мега төслүүдийг санхүүжүүлэх оновчтой шийдлийг Бүгд Найрамдах Казакстан Улсын Самрук-Казына болон Индонезийн баялгийн сан зэрэг олон улсын туршлагад үндэслэн боловсруулж, менежментийн стратегийн төсөлд тусгасан.

3.3.1.20. Үндэсний баялгийн сангаас иргэдэд хэрэгцээтэй дэмжлэгийн зарцуулалтын хувилбаруудыг боловсруулах ажлын хүрээнд Хуримтлалын сангаас орон сууцны зах зээлийн санхүүжилтийн тогтолцоог дэмжих боломж болон ИЗББ хэлбэрээр хөрөнгө оруулах боломжит хувилбарыг судлан шинжлэв. Түүнчлэн Хөгжлийн сангийн зарцуулалтыг тодорхойлох зорилгоор хөгжлийн төслүүдийн мэдээллийг нэгтгэж, холбогдох албан тушаалтнуудтай санал солилцов.

3.3.1.21. Дээрх судалгаа шинжилгээнд суурилсан агуулга бүхий менежментийн стратегийн төслийг гол шийдвэр гаргагч болох Монгол Улсын Ерөнхий сайд, Тэргүүн шадар сайд, ЗГХЭГ-ын дарга, Сангийн яам, ГБХНХ-ын сайд зэрэг төрийн захиргааны төв байгууллагуудын удирдлагууд, бусад төрийн оролцогч талууд болох УИХ гишүүд, Монголбанк, Монголын хөрөнгийн бирж, Үндэсний статистикийн хороо, И-Монголиа зэрэг байгууллагууд, хөрөнгийн зах зээлд идэвхтэй үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн төлөөллүүд, салбартаа нэр хүнд бүхий эдийн засагч, эрдэмтэн судлаачдын төлөөлөл болон хөгжлийн түнш байгууллагууд болох Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк зэрэг байгууллагуудын шинжээч мэргэжилтнүүдэд танилцуулж, санал зөвлөмжүүдийг тусгаж ажиллав.

3.3.2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨГӨГДЛИЙН САН БҮРДҮҮЛЖ, АНАЛИТИК МОДЕЛ ХӨГЖҮҮЛЭВ.

3.3.2.1. Чингис хаан Үндэсний баялгийн сангийн хөрөнгө удирдлагыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд, дунд болон урт хугацааны бодлогын шийдвэр гаргалтад шаардлагатай эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг нэгтгэсэн өгөгдлийн санг бүрдүүлэв. Макро эдийн засгийн дата мэдээлэлд үндэсний статистикийн хороо, Монголбанкны судалгаа, Сангийн яам, Дэлхийн банк, ОУВС, Азийн хөгжлийн банк зэрэг дотоод, гадаадын албан ёсны эх сурвалжид

тулгуурлан ДНБ, инфляц, ажилгүйдэл, төсвийн алдагдал, төлбөрийн тэнцэл, гадаад худалдаа, валютын ханш, гадаад валютын улсын нөөц, түүхий эдийн үнийн индекс зэрэг голлох макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг цуглуулж, ангилсан өгөгдлийн бааз хэлбэрээр боловсруулав. Цаашид энэхүү дата баазыг өргөжүүлэн, бодлогын загварчлал хийх, эдийн засгийн сорилтод хариу арга хэмжээ боловсруулах чадавх бүхий аналитик системд шилжүүлэх, улирал тутмын тайлагнал болон эдийн засгийн төсөөллийг автоматжуулах замаар Үндэсний баялгийн сангийн дотоод дүн шинжилгээний чадамжийг институцийн түвшинд цогцоор нь сайжруулан ажиллахыг зорьж байна.

3.3.2.2. Гадаадын болон дотоод хөрөнгийн зах зээл дээрх санхүүгийн хэрэгслүүд, хөрөнгө оруулалтын сангуудын жишиг багц, бенчмарк болон эрсдэлийн хэмжүүр үзүүлэлтүүдийг судалж, эдийн засгийн өгөгдөл болон Сангийн яам, Монголбанкнаас ирүүлсэн тоон үзүүлэлтэд үндэслэн Ирээдүйн өв сан болон Хуримтлалын сангийн эх үүсвэр, өгөөжийн төсөөллийг гаргаж, сценарийн шинжилгээ хийх боломж бүхий загвар боловсруулав.

3.3.2.3. Түүнчлэн, “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК нь “Эрдэнэс Монгол” ХХК-ийн зээлийн санхүүжилтээр үйл ажиллагаа санхүүжүүлж буй нөхцөл байдлыг өөрчилж, Үндэсний баялгийн сангийн эх үүсвэрийн төрөлжүүлэлтийн шийдэл болон стратегийн ордын хэлэлцээрт мэргэшсэн багаар зөвлөх үйлчилгээ үзүүлэх шийдлийг боловсруулан, тэдгээр үйл ажиллагаанаас орлого олох боломжийг боловсруулсан.

3.3.3. СТРАТЕГИЙН ОРДОД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ ТӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭГ ТОГТООХ АСУУДЛААР ХЭЛЭЛЦЭЭ ХИЙХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭВ.

3.3.3.1. 2025 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн Засгийн газрын 74 тоот тогтоолоор стратегийн ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй хэлэлцээ хийх Бүрэн эрхт төлөөлөгчийг ажиллах нөхцлөөр хангах үүргийг “Эрдэнэс Монгол” ХХК-д даалгасны дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-д Стратегийн ордын хэлэлцээр зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх 6 орон тооны бүрэлдэхүүнтэй нэгжийг байгуулсан. Энэхүү нэгж нь 2025 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн Ерөнхий сайдын 34 дүгээр захирамжаар стратегийн ач холбогдол бүхий тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй хэлэлцээ хийх үүрэгтэй томилогдсон Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй ажиллаж байна. (Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 248 тогтоолоор Бүрэн эрхт төлөөлөгчийг үүрэгт ажлаас чөлөөлж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 139 дугаар тогтоолоор Стратегийн ордын хэлэлцээр зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий 6 хүний орон тоотой нэгжийг татан буулгасан)

3.3.3.2. 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн ЗГХЭГ-ын даргын тушаалаар стратегийн ач холбогдол бүхий ордод тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй хэлэлцээ хийх үүрэгтэй Ажлын хэсэгт мэргэжлийн туслалцаа, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын дэд хэсгийг Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч ахлан ажилласан. Ажлын дэд хэсгийн удирдамжийн дагуу, Ажлын дэд хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан ЗГХЭГ-ын даргаар батлуулж, дотоод зохион байгуулалт, ажил үүргийн хуваарийг

тодорхойлон, санхүү, хууль эрх зүй, геологи-техник технологийн гэсэн 3 хэсэгт хуваарилагдан ажиллаж байна.

3.3.3.3. Энэ хүрээнд стратегийн ач холбогдол бүхий ордын хил заагт үйл ажиллагаа явуулж буй болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох компаниас танилцуулга авах, уулзалт зохион байгуулах зэрэг ажлыг орд тус бүр дээр төлөвлөгөөний дагуу зохион байгуулж байна. Стратегийн ордын хил заагт үйл ажиллагаа явуулж буй “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын үүсмэл орд ашиглагч, Нарийнсухайтын чулуун нүүрсний ордод тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоохтой холбоотойгоор бүрдүүлсэн 24 төрлийн баримт бичгийн мэдээллийн санд тулгуурлан урьдчилсан саналын хувилбар боловсруулах, мэргэжлийн зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар боловсруулах зэрэг бэлтгэл ажлууд хийгдсэн.

3.3.3.4. Ажлын дэд хэсгийн хуралдааны тэмдэглэлийг хөтлөх ажлыг зохион байгуулж, тэмдэглэлийг хянаж тухай бүр ЗГХЭГ-т хүргүүлэв. Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчөөс явсан болон ирсэн нууцад хамаарах баримт бичгийн хуулбар болон цахим архивыг хүлээлгэн өгч ажиллаж байна.

3.3.3.5. Ажлын дэд хэсгийн төлөвлөгөөний дагуу “Ачит Ихт” ХХК, “Эрдмин” ХХК, “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн төлөөлөлтэй 2025 оны 02 дугаар сараас эхлэн 11 дүгээр сарыг дуустал нийт 8 удаагийн уулзалт зохион байгуулж, тэмдэглэл хөтлөв.

3.3.3.6. Үүсмэл ордыг ашиглаж буй хуулийн этгээдийн мэдээллийг нэгтгэн бүтэц, танилцуулга, дүгнэлт, урьдчилсан өгөөжийн хувилбарын санхүүгийн загварыг боловсруулав. Үүсмэл ордын ашиглаж буй хуулийн этгээдийн төлөөлөлтэй 2025 оны 4 дүгээр сарын 27-29-нд хийсэн уулзалтын бэлтгэл ажлыг хангаж, үүсмэл ордын ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаатай танилцаж, хурлын тэмдэглэл хөтлөв.

3.3.3.7. Засгийн газраас өгсөн удирдамжийн дагуу саналын хувилбарыг боловсруулахдаа хөндлөнгийн зөвлөх үйлчилгээний баг ажиллуулах хүсэлтэй байгаа боловч төсвийн хэмнэлтийн хүрээнд дотоод нөөц бололцоогоо ашиглан төрийн захиргааны төв байгууллагаас салбарын мэргэшсэн шинжээч нарыг татан оролцуулах зорилгоор 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч 2/26 тоот бичгээр “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н үүсмэл ордод геологи, техник, технологийн дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчдийн хэсэг томилж өгөх хүсэлтийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад хүргүүлсэн.

3.3.3.8. Энэ хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/92 тоот тушаалаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н үүсмэл орд ашиглаж буй хуулийн этгээдийн геологи, техник, технологийн дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчдийн баг 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр томилогдон, 2025 оны 8 дугаар сарын 5-ны өдөр геологи, техник, технологийн шинжээчдийн хэсгийн дүгнэлтийг Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчид танилцуулан 3 хувь хүлээн авч хувийг ЗГХЭГ, “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-д хүргүүлсэн.

3.3.3.9. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн үүсмэл ордод үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн овоолгын нөөц, баяжуулан боловсруулах үйл ажиллагаанд ашиглаж буй техник, технологи болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээ өгч дүгнэлт гаргах шинжээчдийн хэсэгт нэгжийн зүгээс бүхий л талаар хамтран ажиллаж төрийн болон хувийн хэвшлээс ирүүлсэн баримт мэдээллийг нууцын баталгаа гаргуулан өгч шаардлагатай баримт материалыг нэмэлтээр өгч ажилласан. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үүсмэл ордод үйл ажиллагаа явуулж буй “Эрдмин” ХХК, “Ачит Ихт” ХХК, “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх асуудлаар хэлэлцээрийн урьдчилсан саналын хувилбарыг боловсруулж, Ажлын дэд хэсэгт хүлээлгэн өгсөн.

3.3.3.10. Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчөөс “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн үүсмэл орд ашиглаж буй 3 хуулийн этгээдийн урьдчилсан саналын хувилбарыг Ажлын дэд хэсэгт 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдөр танилцуулан, 2025 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч - 2/92 тоот албан бичгээр саналын хувилбарыг холбогдох мэдээллийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

3.3.3.11. Нарийнсухайтын ордын “Монголын алт МАК” ХХК, “Саус гоби сэндс” ХХК, “Өсөхзоос” ХХК, “Хүрэн толгой коал майнинг” ХХК, “Адилцаг” ХХК, “Онтрэ” ХХК зэрэг хуулийн этгээдүүдэд хэлэлцээ хийх урилга хүргүүлсэн. Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийн ахалсан нэгж 3 дугаар сарын 17, 5 дугаар сарын 2-ны өдөр “Эрдэнэс Оюу толгой” ХХК болон “Оюу толгой” ХХК, “Онтрэ” ХХК-ийн асуудлаар мэдээлэл солилцох уулзалт хийв. Ажлын дэд хэсэг батлагдсан төлөвлөгөөний дагуу Нарийн сухайтын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Саус гоби сэндс” ХХК-ийн ажлын хэсэгтэй 4 дүгээр сарын 24-ний өдөр, “Нэт говь энерги” ХХК-тай 4 дүгээр сарын 21-ний өдөр, “ЕАИ” ХХК-тай 5 дугаар сарын 21-ний өдөр, Төмөртэйн овоо ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Цайрт минерал” ХХК-ийн ажлын хэсэгтэй 5 дугаар сарын 07-ний өдөр тус тус уулзалт зохион байгуулж, уулзалтын тэмдэглэл хөтлөв.

3.3.3.12. “Нарийнсухайт”-ын чулуун нүүрсний ордод үйл ажиллагаа явуулж буй “Монголын алт МАК” ХХК, “Хүрэн толгой коал майнинг” ХХК, “Өсөх зоос” ХХК, “Саусгоби сэндс” ХХК, “ЕАИ” ХХК, “Адилцаг” ХХК-ийн урьдчилсан саналын хувилбар боловсруулах ажлын хүрээнд төр болон хувийн хэвшлийн байгууллагаас 24 төрлийн баримт мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийн, урьдчилсан саналын хувилбар, тооцоолол гарган ажлын дэмжлэг үзүүлсэн.

3.3.3.13. 2025 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн Ерөнхий сайдын 72 дугаар захирамжаар байгуулагдсан дараах 3 ажлын хэсэгт гишүүнээр болон дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Үүнд: (i) Төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, түүнийг Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ)-өөр орлуулах эсэх асуудлаар хэлэлцээ хийх, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг; (ii) Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулан, Стратегийн ач холбогдол бүхий ордын тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу олгосон эсэхийг шалгаж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын дэд хэсэг; (iii) Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулан, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын дэд хэсэг болно. Энэ захирамжийг үндэслэн ЗГХЭГ-ын даргын 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 101 дүгээр тушаалаар Ажлын дэд хэсгийг шинэчлэн байгуулсан.

Ажлын хэсэг байгуулагдсантай холбогдуулан Стратегийн ач холбогдол бүхий ордод тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэгт мэргэжлийн туслалцаа, дэмжлэг үзүүлэх Ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүний удирдамжийн дагуу Ажлын дэд хэсгийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан батлуулсан.

3.3.3.14. Стратегийн ордын хил заагт тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хэлэлцээ хийхэд дэмжлэг үзүүлэх нэгжийн зүгээс Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчид төрийн болон хувийн хэвшлийн хуулийн этгээдүүдээс Стратегийн орд эзэмшигч хуулийн этгээдийн Төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоохын тулд шаардлагатай мэдээллүүдийг цуглуулах үүднээс нийт 126 албан бичгийн төслийг боловсруулж, 64 албан хариу бичгийн төслийг боловсруулан дэмжлэг үзүүлсэн.

3.3.3.15. “Эрдэнэтийн зэс молибдений орд”-ын технологит нийцэхгүй овоолгод (үүсмэл орд) үйл ажиллагаа явуулж буй нэр бүхий 3 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаандаа ашиглаж буй овоолгын нөөц, чанарын үзүүлэлт, баяжуулан боловсруулах үйл ажиллагааны техник, технологи болон тэдгээрийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх хүчин төгөлдөр ашиглаж буй нөөцийн тайлан, техник эдийн засгийн үндэслэл, түүний тодотголд үндэслэсэн мэргэжлийн тайлбар, зөвлөмж, санал боловсруулан хүргэх үүрэг бүхий шинжээч нартай ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан.

3.3.4. ИРГЭДИЙН ДУНД СУДАЛГАА ХИЙЖ, ОРОЛЦООГ ХАНГАХ ЗАМААР ОЛОН НИЙТИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАЖ АЖИЛЛАВ.

3.3.4.1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн энгийн хувьцааны 2024 оны 2 болон 3 дахь удаагийн ногдол ашгийг хэрхэн хүлээн авах тухай санал асуулгыг “И-Монголиа” цахим системээр дамжуулан явуулж, эхний удаад 505,318 иргэн, хоёр дахь удаагийн судалгаанд 270,361 иргэн оролцож, санал асуулгаар 4,026 иргэн ногдол ашгаа Хуримтлалын нэрийн дансанд хуримтлуулах, 85 иргэн Хөгжлийн санд хандивлах хүсэлт гаргасан. Түүнчлэн 100,000 гаруй иргэдийн дунд Үндэсний баялгийн сангийн тухай нээлттэй асуулга явуулж, хариултад дүн шинжилгээ хийн менежментийн стратегийн төсөлд олон нийттэй харилцах стратеги хэлбэрээр тусгасан.

3.3.4.2. Иргэдийн саналыг харгалзан ногдол ашгийн төлбөрийг Монгол банканд байршиж буй Хуримтлалын сан болон Хөгжлийн сангийн төрийн сангийн данс руу шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад холбогдох байгууллагуудтай хамтран, дэмжлэг үзүүлж ажилласан.

3.3.4.3. Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2025 оны 4 дүгээр сарын 19-ний өдрөөс хэрэгжиж эхлэснээс хойш нэг жилийн хугацаанд Засгийн газраас иргэн бүрт Хуримтлалын нэрийн данс нээж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зорилгоор зарцуулах боломжийг бүрдүүлэх, холбогдох дүрэм журмыг батлах зэрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, явцын талаар танилцуулсан мэдээлэл, илтгэл бэлдэх, D-Parliament системээр иргэдийн ирүүлсэн асуултад хариу бэлдэх зэргээр дэмжлэг үзүүлсэн.

3.3.4.4. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үлдэгдэл ногдол ашиг хуваарилахтай холбогдуулан төрийн цахим үйлчилгээний И-Монголиа системээр авсан санал асуулгын талаар С-1, Боловсрол телевизэд ярилцлага өгч, олон нийтэд үнэн, зөв мэдээлэл хүргэж ажилласан.

3.3.4.5. Үндэсний баялгийн сангийн албан ёсны вэбсайтыг (www.swf.gov.mn) эхний байдлаар Монгол болон Англи хэл дээр ашиглалтад оруулж, таван холбогдох домайнаас үндсэн хаяг руу чиглүүлэгдэн нэвтрэх боломж бүрдсэн. Цаашид уг вэбсайт нь олон нийтэд ил тод, нээлттэй байдлаар мэдээллийг цаг тухайд нь шинэчилж хүргэх гол хэрэгсэл байх болно.

3.3.4.6. Үндэсний баялгийн сангийн үр шим хүртэгсэд болох иргэдэд баялгийн сангийн тухай ойлголтыг өгөх, итгэл үнэмшил нэмэгдүүлэх, цаашид иргэд баялгийн сангийн зорилго, үйл ажиллагааг үргэлжлүүлэн дэмжих итгэлцлийг бататгах чиглэлээр цахим сүлжээ, олон нийтийн мэдээллийн сайтуудын Үндэсний баялгийн сангийн талаарх аливаа медиа контентууд түгээж, гуравдагч сувгаас гарсан мэдээллүүдэд мониторинг, дүн шинжилгээ хийн ажиллаж байна. Фэйсбүүк (Facebook) сувагт 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 5,997 дагагчтай болсон бөгөөд 78 пост тавигдаж, 856,786 үзэлт болон 4,899 хандалттай байна. Үүний дотор видео 22, зурагт хуудас 50, мэдээ нийтлэл 6 байна. ЛинкидИн (LinkedIn) сувгийн хувьд, 527 дагагчтай болсон бөгөөд 12 пост тавигдаж, 310 хандалт болон 42,102 үзэлттэй байна.

3.3.5. СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОЖ, БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНҮҮЛЖ, САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАВ.

3.3.5.1. “Монголын эдийн засгийн форум 2025”-ын үеэр “Урт хугацааны баялгийн удирдлага” сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулж, панелист, модераторуудтай агуулгыг чиглүүлэн ажиллав. Мөн салбар хуралдааны үеэрх гол ишлэлүүдийг сошиал болон уламжлалт сувгаар түгээн ажиллав.

3.3.5.2. “Монголын эдийн засгийн форум 2025”-ын үеэр 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдөр JP Morgan байгууллагаас Улаанбаатар хотноо зохион байгуулсан Leaders Summit хаалттай арга хэмжээнд оролцож, “Financial Markets & investment, Economic Diversification & Growth, AI & Opportunities” сэдэвт хэлэлцүүлгийн хүрээнд олон улсын банк санхүүгийн байгууллагуудын төлөөлөл, Монгол Улсын бодлого баригч, хувийн хэвшлийн төлөөллийн дунд Үндэсний баялгийн сангийн танилцуулга хийж, хамтын ажиллагааны боломж эрэлхийлэв.

3.3.5.3. Монгол Улсын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны гол платформ болох “Mining Week & MinePro 2025” арга хэмжээнд амжилттай оролцон, “Эрдэнэс Монгол” нэгдлийн асарт мэдээллийн цэг ажиллуулан сангийн үйл ажиллагаа, зорилго, чиг үүргийг олон нийтэд таниулав. “Үндэсний баялгийн сан: өнөөгийн нөхцөл байдал, дэлхийн чиг хандлага” сэдвээр илтгэл тавьж, оролцогчдод олон улсын жишиг, судалгаанд суурилсан дүгнэлтүүдийг танилцуулсан. Энэхүү оролцоог дэмжих зорилгоор цахим сурталчилгааны цогц ажлыг зохион байгуулж, Гүйцэтгэх захирал болон Тэргүүн шадар сайдын ярилцлага, арга хэмжээний сурвалжилга, орлого төвлөрүүлэгч байгууллагуудад хандсан талархлын контент зэргийг олон нийтэд

хүргэв. Нийтдээ 17 цахим контент бэлтгэн нийтэлсэн нь давхардсан тоогоор 6,386 хүнд хүрч, 199 идэвхтэй хандалт авсан нь сангийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд чухал алхам болов.

3.3.6. ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, БАЯЛГИЙН САНГУУДАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА ТОГТООЖ, ЦААШИД ХАМТАРЧ АЖИЛЛАХ СУУРИЙГ ТАВИВ.

3.3.6.1. Олон улсын баялгийн сангуудын холбоод, хамтын ажиллагааны механизмуудыг судалж, олон улсын зах зээлийн судалгаа, баялгийн санг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа эрхлэн явуулдаг Баялгийн сангийн институт (SWFI)-д гишүүнээр элсэх бэлтгэл хангаж, 2025 оны 6 сарын 19-ний өдөр 3 жилийн гишүүнчлэлийн төлбөрөөс чөлөөлөгдөх ажлыг зохион байгуулав. Тус байгууллага нь 2008 онд АНУ-д байгуулагдсан бөгөөд нийт 10 их наяд ам.доллар удирддаг дэлхийн томоохон төрийн өмчит хөрөнгө оруулалтын сан, төв банк, тэтгэврийн сан болон бусад институцийн хөрөнгө оруулагчид гишүүнчлэлтэй, судалгаа, өгөгдөл, зөвлөх үйлчилгээ болон стратегийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулдаг хараат бус, олон улсын байгууллага юм.

3.3.6.2. 2025 оны 6 дугаар сард жил бүр нийт 5 их наяд ам, долларын хөрөнгө удирддаг баялгийн сангууд цугладаг “Global Wealth Conference” арга хэмжээнд “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-иас урилгаар оролцсон бөгөөд тус арга хэмжээний үеэр сангийн танилцуулга хийж, Монголын хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах ажлыг зохион байгуулав. Ингэхдээ “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийн төлөөлөл “Funding the Future” сэдэвт хэлэлцүүлэгт панелистаар оролцож, “The Future of Sovereign Wealth Funds” сэдвээр илтгэл тавив.

3.3.6.3. Мөн 2025 оны 6 дугаар сард Бүгд Найрамдах Франц Улсын Парис хотноо зохион байгуулагдсан “Европын эдийн засаг, санхүүгийн зөвлөгөөн 2025”-нд “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийн төлөөлөл оролцов.

3.3.6.4. 2025 оны 8 дугаар сард Бразил улсын Institute for Sovereign Wealth Fund Studies (IEFS) байгууллагатай цахим уулзалт хийж, хамтын ажиллагааны эхлэлийг тавив. Уулзалтын хүрээнд “Чингис хаан Үндэсний баялгийн сан”-г ирэх оноос эхлэн тус байгууллагаас жил бүр эрхлэн гаргадаг олон улсын баялгийн сангийн судалгаанд нэгтгэн хамруулах талаар урьдчилсан тохиролцоонд хүрсэн. Энэ нь дэлхийн баялгийн сангуудын эрэмбэ, чансааг тодорхойлдог бөгөөд хамрагдсанаараа олон улсад албан ёсны статусаа бэхжүүлж, менежментийг сайжруулах зөвлөмж тайлан үнэ төлбөргүй авах ач холбогдолтой.

3.3.6.5. 2025 оны 8 дугаар сард Хөгжлийн сангийн зарцуулалт болон цаашид санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг олон улсын стандарттай нийцүүлэх зорилгын хүрээнд Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк (АДХОБ)-ны хамтын ажиллагаа болон хөрөнгө оруулалт хариуцсан төлөөлөгчидтэй цахим уулзалтыг зохион байгуулав. Уулзалтын үеэр АДХОБ-ны хэрэгжүүлдэг төсөл, хөтөлбөрүүдэд тавигддаг шаардлагын талаар мэдээлэл солилцож, мөн сангийн албан хаагчдын чадавх бэхжүүлэх сургалтад хамруулах боломжийн талаар хэлэлцэв.

3.3.6.6.2025 оны 9 дүгээр сард УИХ-ын даргын Бүгд Найрамдах Казакстан Улсад айлчилсан дээд хэмжээний айлчлалын үеэр тус улсын баялгийн сан болох “Самрук-Казына”-тай хийх уулзалтанд зориулж “Чингис хаан Үндэсний баялгийн сан”-гийн танилцуулга болон сэргээгдэх эрчим хүч, дэд бүтэц, уул уурхай боловсруулах үйлдвэр зэрэг хөгжлийн төсөл хөтөлбөрүүдэд хамтран хөрөнгө оруулах, хоёр улсын хоорондын худалдааны хэмжээг 500 сая ам.долларын түвшинд хүргэх боомт, тээвэр, худалдааны дэд бүтцийг хөгжүүлэх, төрийн өмчит компаниудын хүрээнд стратегийн түншлэл байгуулах зэрэг олон талт чиглэлээр хамтын ажиллагааны саналыг бэлтгэн хүргүүлэв.

3.3.6.7.2025 оны 10 дугаар сард дэлхийн санхүү, хөрөнгө оруулалтын салбарын нөлөө бүхий манлайлагчид чуулдаг “Милкений Хүрээлэнгийн Азийн 12 дахь удаагийн Дээд хэмжээний чуулган”-д “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийн төлөөлөл урилгаар оролцож, олон улсын хөрөнгө оруулагчдад сангийн үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулав. Мөн Сингапур улсад болсон тус арга хэмжээний үеэр “CEO Breakfast” болон “Valuations, Volatility, and the Future of Alternatives” зэрэг өндөр түвшний хэлэлцүүлгүүдэд албан ёсны илтгэгчээр оролцож, Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин, сангийн стратегийг танилцуулав. Мөн чуулганы хүрээнд Азийн тэргүүлэх баялгийн сан Temasek, дэлхийн томоохон хөрөнгө удирдлагын компани PIMCO, Brookfield зэрэг байгууллагуудын удирдлагатай стратегийн уулзалтууд хийж, хамтын ажиллагааны эхлэлийг тавьсан нь сангийн олон улс дахь байр суурийг бэхжүүлэхэд чухал түлхэц болов.

3.3.6.8.2025 оны 10 дугаар сард “Сантьяго зарчим”-ын хэрэгжилтийг үнэлж баталгаажуулдаг Олон улсын Үндэсний баялгийн сангийн форум (IFSWF)-ын 2025 оны дээд хэмжээний чуулга уулзалтад “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийн төлөөллүүд оролцож, сангийн засаглал, ил тод байдлыг олон улсын түвшинд таниулах ажлыг амжилттай хэрэгжүүлэв. Абу Даби хотноо болсон тус чуулганы үеэр “IFSWF CEO Forum” болон салбар хэлэлцүүлгүүдэд оролцож, Монгол Улсын баялгийн сангийн бодлого, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлав. Түүнчлэн Абу Дабигийн Хөрөнгө оруулалтын газар (ADIA), Мубадала, Аляскийн Байнгын Сан зэрэг дэлхийн тэргүүлэгч сангуудын удирдлагатай хийсэн стратегийн уулзалтуудын үр дүнд “Чингис хаан Үндэсний баялгийн сан”-гийн гишүүнчлэлийн асуудлыг урагшлуулж, институцийн чадавхыг бэхжүүлэх, техникийн туслалцаа авах чиглэлээр хамтран ажиллах түншлэлийн суурийг тавив.

3.3.6.9. Азийн хөгжлийн банктай стратегийн түншлэлийн хүрээнд уулзалтыг зохион байгуулж, хамтран ажиллах боломж, тус банкнаас Үндэсний баялгийн сангийн хөрөнгө удирдлагыг хэрэгжүүлэх замын зураглал гаргах чиглэлээр техникийн туслалцаа авах боломжийн талаар харилцан санал солилцов. Мөн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP)-тэй “Хөгжлийн сан”-гийн үйл ажиллагааг дэмжих, НҮБ-ын Хөрөнгө оруулалтын хөгжлийн сан (UNCDF)-тай холбоо тогтоох, ногоон санхүүжилтийн чиглэлээр хамтран ажиллах эхлэлийг тавьсан бол Дэлхийн банк (World Bank)-тай сангийн хөрөнгө оруулалтын чадавхыг бэхжүүлэх “RAMP” (Reserve Advisory & Management Partnership) хөтөлбөрт нэгдэх асуудлаар санал солилцлоо.

3.3.6.10. Тайлант хугацаанд Чингис хаан Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагаа, стратегийн шинэчлэлийн талаарх мэдээлэл нь дэлхийн нэр хүнд

бүхий хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр нийтлэгдсэн. Тухайлбал, Reuters, CNBC, PRNewswire зэрэг дэлхийн томоохон мэдээллийн сувгууд сангийн талаарх 10 гаруй нийтлэл, мэдээ мэдээллийг албан ёсоор нийтлэсэн. Эдгээр нийтлэлүүд нь АНУ, Австрали, Энэтхэг, Сингапур тэргүүтэй улсуудын нийт 282 сая хэрэглэгчдэд хүрсэн байна. Энэ нь Монгол Улсын баялгийн сангийн засаглалын ил тод байдал, хөрөнгө оруулалтын орчин, ирээдүйн зорилтуудыг олон улсын хөрөнгө оруулагчид болон шийдвэр гаргагчдад таниулахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа юм.

3.3.7. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ДҮРЭМ ЖУРМЫГ БОЛОВСРУУЛАН БАТАЛЖ, ТӨЛӨВЛӨГӨӨ ТАЙЛАГНАЛ, ХЯНАЛТЫН МЕХАНИЗМЫГ БҮРДҮҮЛЭВ.

3.3.7.1. “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК нь 2025 оны 2 дугаар сарын 21-ний өдөр “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 100 хувийн охин компани хэлбэрээр байгуулагдаж, “Эрдэнэс Монгол” Нэгдлийн засаглалын бодлого журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус байгууллага нь 2025 онд Монгол Улсын газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг арвижуулж, өнөө болон ирээдүй хойч үеийн иргэддээ тэгш, шударга хүртээх нөхцөлийг бүрдүүлэх болон компанийн дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

3.3.7.2. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 17 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Компанийн 2025 оны Бизнес төлөвлөгөөг төсвийн хамт боловсруулан холбогдох газарт хүргүүлж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 103, 104 дүгээр тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

3.3.7.3. Бизнес төлөвлөгөөг үндэслэн дараах Дэд төлөвлөгөөнүүдийг боловсруулан, гүйцэтгэх захирлаар батлуулан ажиллаж байна. Үүнд:

- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө;
- Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын төлөвлөгөө;
- Сургалт, хөгжлийн төлөвлөгөө;
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө

3.3.7.4. Мөн түүнчлэн Компанийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах ажлын хүрээнд гүйцэтгэх захирлын тушаалаар 13 дотоод дүрэм, журмуудыг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллав. Үүнд:

1. Хөдөлмөрийн дотоод журам
2. Гүйцэтгэлийн удирдлагын журам
3. Цалин хөлсний журам
4. Ажлын байрны тодорхойлолт
5. Албан бичгийн индекс батлах

6. Албан томилолтоор ажиллуулах журам
7. Ёс зүйн дүрэм
8. Дотоод хяналт хэрэгжүүлэх журам
9. Ёс зүйн дэд хорооны ажиллах журам
10. Компанийн хурал, уулзалт зохион байгуулах журам
11. Хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийттэй харилцах журам
12. Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам
13. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн журам

3.3.7.5. Тайлант хугацаанд дээд газрын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж, биелэлтийг тухай бүр гарган ажиллалаа. Үүнд:

- УИХ-ын 2025 оны 42 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны 61 дүгээр тогтоол (Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулах, шинэчлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай);
- Засгийн газрын 2025 оны 6 дугаар хуралдааны тэмдэглэл;
- Засгийн газрын 2025 оны 9 дугаар хуралдааны тэмдэглэл;
- Засгийн газрын 2025 оны 12 дугаар хуралдааны тэмдэглэл;
- Засгийн газрын 2025 оны 14 дүгээр хуралдааны тэмдэглэл;
- Засгийн газрын 2025 оны 18 дугаар хуралдааны тэмдэглэл;
- Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгавар (Ажил сайжруулах тухай);
- Ерөнхий сайдын 2025 оны 72 дугаар захирамж;
- Эрдэнэс Монгол нэгдлийн ТУЗ-аас гаргасан тогтоолын хэрэгжилт (№15-“Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийн дүрэм батлах тухай, №16-“Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийн зохион байгуулалтын бүтэц орон тооны хязгаарыг батлах тухай, №17-“Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийн 2025 оны төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай, №74-Дотоод аудитын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай /Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт/)

3.3.7.6. Компанийн эрх бүхий албан тушаалтнуудыг томилохдоо Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт заасны дагуу Авлигатай тэмцэх газартай зөвшилцсөний үндсэн дээр томилон, эрх бүхий 4 албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд хүлээн авч, бүртгэн баталгаажуулсан.

3.3.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫГ СТАНДАРТЫН ДАГУУ ЦАГ ТУХАЙД НЬ БОЛОВСРУУЛЖ, ХУДАЛДАН АВАЛТЫГ ЗОХИХ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

3.3.8.1. Санхүүгийн үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 76 дугаар тогтоолоор батлагдсан

“Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”, 2023 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын олон улсын төлбөр тооцооны хэрэгсэл ашиглах журам” болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны А/195 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөр тооцоо гүйцэтгэх журам”-ыг баримтлан ажиллаж, ажилтнуудын цалинг сар бүр тооцон олгож, нийгмийн даатгалын болон бусад тайланг хуулийн хугацаанд нь гарган холбогдох байгууллагад тайлагнан ажиллав.

3.3.8.2.Компанийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан мэдээг сар бүр гарган удирдлагад танилцуулж, мэдээллийг хуулийн хугацаанд шинэчлэн шилэн дансанд 4 удаа байршуулсан. Түүнчлэн Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 1, 2, 3 дугаар улирлын байдлаар үнэлгээ хийж “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлж ажилласан.

3.3.8.3.Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах ажлын хүрээнд www.shilen.gov.mn цахим хуудаст бүртгүүлж админ эрх авах ажлыг зохион байгуулсан.

3.3.8.4.Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын оффисын байрны түрээсийн үйлчилгээ, ажилчдын албан хэрэгцээнд шаардлагатай тавилга, эд хогшил болон компьютер тоног төхөөрөмж худалдан авах тендерүүдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу зохион байгуулж, оролцогчдыг шалгаруулан, худалдан авах ажиллагааны цахим системд нийтлэн ажилласан. Тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан оролцогч компаниудтай гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтийг ханган эд хогшлыг актаар хүлээн авч, холбогдох журмын дагуу бүртгэн, ажилтнуудад хүлээлгэн өгч албан хэрэгцээнд ашиглаж байна.

3.3.9. АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙГ СТАНДАРТЫН ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЭВ.

3.3.9.1. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомж тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмууд, Баримт бичгийн MNS1,2,3, 5140.2021 стандартыг мөрдөн ажиллаж, удирдлагын үйл ажиллагааг баримтжуулах зорилгоор тушаал, албан бичиг, гэрээ, төлөвлөгөө, тайлан, танилцуулга, илтгэх хуудас, тодорхойлолт, удирдамж, хурлын тэмдэглэл, дүгнэлт, албан шаардлага зэрэг зохион байгуулалт, мэдээлэл лавлагааны баримт бичгийг зохион бүрдүүлэн ажиллав.

3.3.9.2. А4, А5 хэмжээтэй хэвлэмэл хуудас болон тушаалын бланкын загварыг шинээр боловсруулж, 2025.08.28-ны 1/058 албан бичгээр Архивын ерөнхий газар хүргүүлж батлуулсан. Батлагдсан загварын дагуу А4-100, А5-100, тушаалын бланк 150 ширхэг хэвлүүлж, байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж эхэлсэн.

3.3.9.3. Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 39, хүний нөөцийн чиглэлээр 68 тушаал гарсан байна. 59 албан бичиг ирснээс хариутай бичиг 9, хугацаа хоцроож шийдвэрлэсэн бичиг байхгүй. 95 албан бичиг боловсруулж илгээсэн. Өргөдөл гомдол ирээгүй.

3.4. Үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

“Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК нь 2025 онд Компанийн дүрэмд заасан үйл ажиллагааны үндсэн чиглэлийн дагуу нийт 5 стратегийн зорилгын хүрээнд

15 зорилтыг дэвшүүлж, 44 цогц арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн. Уг бизнес төлөвлөгөөг 2025 оны 3 сарын 31-ний өдөр “Эрдэнэс Монгол” ХХК-д хүргүүлсэн бөгөөд ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 103 дугаар тогтоолоор батлагдсан.